**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 08 сарын 12 өдөр Дугаар 295 Улаанбаатар хот

Балетийн мэргэжлээр сургах тухай

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах хөтөлбөр, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Оросын Холбооны Улсын Соёлын яам хоорондын 2009 – 2011 оны хамтын ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын сонгодог урлагийг хөгжүүлэхэд нэн шаардлагатай байгаа балетийн жүжигчин мэргэжлээр хавсралтад нэр дурьдсан хүүхдүүдийг Оросын Холбооны Улсын Перм хотын Бүжгийн коллежид 2010-2011 оны хичээлийн жилээс эхлэн суралцуулсугай.

2. Балетийн жүжигчин мэргэжлээр суралцах хүүхдүүдийг хариуцан ажиллах асран хүмүүжүүлэгч багшаар Монгол Улсын гавьяат жүжигчин Доржийн Алтантуяаг томилон ажиллуулсугай.

3. Балетийн жүжигчин мэргэжлээр суралцах хүүхдүүд болон багшийн амжиргааны тэтгэлэг олгох, гэрээ байгуулан, холбогдох зардлыг тухайн сургуулиас баталсан тарифын дагуу жил бүр төсөвт тусгаж байхыг Сургалтын төрийн сангийн захирал Д.Нансалмаад зөвшөөрсүгэй.

4. Багш Д.Алтантуяатай гэрээ байгуулж, хөдөлмөрийн хөлсийг тооцож олгохыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранцогт нарт тус тус даалгасугай.

САЙД Ё.ОТГОНБАЯР

C/My doc/ alban.b/ Tushaal

1100897

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 8 дугаар сарын 12 өдрийн 295 дугаар тушаалын хавсралт

Оросын Холбооны Улсад 2010-2011 оны хичээлийн жилд Балетийн жүжигчин мэргэжлээр суралцах оюутны нэрс

| д/д | Овог нэрс | нас | хүйс |
|---|---|---|---|
| 1 | Цолмонгийн **Эрхэс** | 12 | Эр |
| 2 | Мөнгөнчавхдасын **Золжавхлан** | 12 | Эр |
| 3 | Өлзийжаргалын **Мөнхжин** | 10 | Эр |
| 4 | Бат-Эрдэнийн **Молор** | 11 | Эр |
| 5 | Цолмонгийн **Энх-Амар** | 13 | Эр |
| 6 | Хаш-Эрдэнийн **Дөлгөөн** | 11 | Эр |
| 7 | Дэмбэрэлийн **Хишиг** | 12 | Эм |
| 8 | Батбаярын **Манахатан** | 10 | Эм |
| 9 | Баясанжавын **Мөнхнаран** | 11 | Эм |
| 10 | Гантулгын **Нямцэрэн** | 10 | Эм |
| 11 | Оюунболдын **Энхмөнх** | 11 | Эм |
| 12 | Рэнцэндоржийн **Булган** | 11 | Эм |

- - - o O o - - -